



## ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨР




### Эзэмших мэдлэг, ур чадвар

Тус хөтөлбөр нь газрыг хавтгайд болон орон зайд зураглах, бүртгэх, хуваарилах, мэдээллийн сан бүрдүүлэх, зохион байгуулах, төлөвлөх, хууль эрх зүйн хүрээнд газрыг зүй зохистой ашиглах, хамгаалах, захиран зарцуулах зэргээр үнэлэх, төлбөр татвар тооцох, хяналт тавих зэрэг үйл ажиллагаануудыг гүйцэтгэхээс гадна газрын харилцааны тулгамдсан асуудлуудыг оновчтой тодорхойлох, шийдвэрлэх чадвар олгоход чиглэгдэнэ.



### Давуу тал



- Орчин үеийн дэвшилтэт технологиуд болох дрон, лазер сканнер, GPS болон бусад хэмжилт, зураглалын багаж, програм хангамж дээр ажиллаж сурах,
- Иж бүрэн тохижуулсан сургалтын орчин, Тэрэлж байгалын цогцолбор газарт байрлах хээрийн дадлагын талбай,
- Улс орны тогтвортой хөгжлийн суурь болох “Газар” хэмээх өргөн хүрээтэй салбарын мэргэжилтэн болсноор бусад олон салбарт хөрвөж ажиллах боломжтой.



### Ажлын байр

- Барилга хот байгуулалтын яам,
- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар,
- Нийслэлийн болон дүүргийн ГЗБ-ын алба,
- Сум, орон нутагт газрын асуудал хариуцсан мэргэжилтэн, газрын даамал,
- Энэ чиглэлээр мэргэжлийн байгууллагууд.

